



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/110

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ӨВАХУСЗДТГ/202301015” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Бямбасүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Л.Цэдэв (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Д.Уранчимэг (Ерөнхий нягтлан бодогч)


Д.Норов (Иргэний төлөөлөл- зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж бүрдүүлэн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ